



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/541

Чингис хот

“Эрх зүйн хөтөч”-ийн буланг тохижуулахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.2, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.20 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 50 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 03 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хууль зүйн зөвлөгөө мэдээлэл, сурталчилгааны "e-khutuch" портал цахим хуудсыг ашиглалтад оруулах танилцуулах "Жишиг аймаг" болох зорилгоор аймгийн сумд, тосгодод "Эрх зүйн хөтөч"-ийн буланг тохижуулах, баннер хийлгэх зардалд 1.000.000 /нэг сая/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын "Архидалтгүй Хэнтий" дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг сайтар зохион байгуулахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Б. Дарханбаатар/-т, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ